

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Бямбаа	Дугаар	L236
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Баяндалай
Төрсөн газар	Баяндалай сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шавран гэгээний хийд	Сүм хийдийн дугаар	ӨГБД 016
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 8	Ярилцлага авсан хүн	Ц. Гантулга

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Шавран гэгээний хийд

Гантулга: Та эхлээд овооныхоо тухай ярихгүй юу? Тахилгатай овооныхоо тухай, ийм нэртэй овоо тахидаг байсан гээд?

Бямбаа: Энэ тахидаг овоог тэр Шавран лам гэдэг хүн өөрөө тахидаг байсан гэж байгаа юм одоо тэгээд ламын овоо л гэж ярьдаг юм. Чухам өшөө ямар нэртэй байсныг нь би сайн мэдэхгүй юм. Зүгээр энэ овоонд хоёр морь чөдөрлөдөг хүн байсан юм гэнэ лээ. Тэр хоёр морийг анх чөдөрлөхдөө дааганаас нь эхлээд хүн мордуулаад булгихлаар нь оочиж унаад л. Тэгээд л оочуулсаар байгаад л, тэгээд сүүлдээ бүр мордсон хүнийг унагаж салгадаг болсон. Тэр хоёр морийг. Борооноор тэгээд нөгөө оноонд нь ус тогтож байсан гэдэг.

Гантулга: Оноонд нь?

Бямбаа: Борооноор оноо дагаад хонхор гардаг байхгүй юу. Борооны ус тогтсон давхиж явдаг байсан гэж ярьдаг. Тэгээд тэр хоёр морийг нь хүн тогтоохоо больчихсон. Тэгээд тэр адууны улсууд, дуран Балжин гэж нэг өвгөн байсан юм. Сүүлдээ таг сохор болсон доо. Моринд сайн булгидаг моринд тогтдог. Тэгээд тэр адууны улсууд маанай эцэг эд нар ахаас жаахан айдаг. Тэгээд эзгүйгээр нь л Балжинг л тогтохын нь үзэх гэж. Тэгээд овооны шарга дээр мордуулсан юм байна л даа, хөдөө. Тэгээд л булгилж гарсан. Тэгээд тогтож тогтож тавьж уячихаад хүрээд ирсэн. Нөгөө лам гэртээ ирчихээд мэдчихсэн. Шарга морь мөн булгилж байдаг, чи их тогтож байдаг./инээв/ Ийм л түүхтэй байдаг.

Гантулга: Тэгээд тэр шарга морь чинь?

Бямбаа: Тэгээд тэр хоёр морь тэрүүхэн бөөр хавиар байдаг. Тэгээд овоо тахихад бол овоон дээрээ гаргаад л хариулаагүй болгочихдог, тавьчихдаг. Тэгээд л давхиад л тэр наадам хийдэг Шар усны хадны тэр хавиар...

Гантулга: Овоо тахихаар л өөрсдөө хүрээд ирдэг?

Бямбаа: Тийм, өөрсдөө хүрээд ирдэг гэдэг ч байсан юм уу, яадаг байсан юм бодвол. Өөрсдөө барьдаг ч байсан юм уу.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр хавиасаа л холддоггүй?

Бямбаа: Тийм, холддоггүй морь байсан гэж байгаа юм. Тэгээд л тэр овоо хавиараа байж байгаад л наадамчид тарахаар л сүрэг рүүгээ буцаад явчихдаг. Тийм хоёр морь.

Гантулга: Бөөр гэдэг нь тэр амныхаа ус нь уу?

Бямбаа: Бөөр гэдэг дээр тэр хярд хаанахын баруун зоогийн ард нэг ус байдаг юм. Тэр нөгөө нэг аравнайлсан юу гэж Бөөрөөс авдаг нэг Ариадан гэж арц байдаг юм .

Гантулга: Аан арц ургадаг?

Бямбаа: Тийм, арц ургадаг. Тэр лам ном уншаад аравнайлчихсан.

Гантулга: Тэр арц ургадаг газар нь уу?

Бямбаа: Тийм, жоохон газар юм билээ.

Гантулга: Тэгээд одоо яривал яг хаахна байна?

Бямбаа: Тэр овооноос л , ламын овооноос л дээших нь бий л дээ

Гантулга: Ууландаа юу, энэ Сайхан уулыг л яриад байна уу?

Бямбаа: Тийм. Баруун Сайхны зүүн үзүүрт л байгаа юм.

Гантулга: Байгаа газар нь уу?

Бямбаа: Байгаа газар нь .Тэр Дасгын даваа гэдгийн яг ар цайр дээр нь байгаа юм.Тэгээд нэг Дунд худгийн ар талд Шарын Шаст гэж байдаг юм. Тэгээд Шарын Шастад бас нэг жоохон дугуй арц байдаг юм. Бас аравнайлсан арц гэж байгаа юм. Тэгээд тэр хоёрыг тэгээд энэ Зүүн Сайханд бас арц байдаг юм гэнэ лээ, энэ гурвыг нийлүүлсээд утах юм бол ер нь маш их сайн гэж ярих юм билээ. Одоо чухам мэдэхгүй юм даа.

Гантулга: Одоо энэ Шавроон ламын түүхтэй холбоотой , одоо газар усны түүхтэй холбоотой ,тэр лам тэгж арцыг нь аравнайлжээ гэдэгтэй адилхан өөр түүхтэй газар байна уу, энэ хавиар?

Бямбаа: За тэр талаар ч сайн мэдэх юм алга даа. Ерөнхийдөө энэ ар өвөр талаар нутагладаг айл л байсан юм гэнэ лээ.

Гантулга: Уул нутаг нь бол?

Бямбаа: Тийм, өөрөө их малчин хүн байсан юм гэнэ лээ.Дандаа л малдаа давхиж явдаг. Тийм л хүн байсан юм гэнэ лээ.

Гантулга: За баярлалаа. Шавроон гэгээнийхээ талаар маш сайхан ярилцлага өгсөнд тань маш их баярлалаа.Лам ахынхаа тухай үүх түүхээс нь ярьж өгсөнд тань баярлалаа.

Бямбаа: За маш их баярлалаа. Та бүгдийн ажил үйлс амьдралд чинь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.Энэ явж байгаа зам чин өлзийтэй сайхан байхыг хүсэн ерөөе, ах нь .

Гантулга: За тэр ерөөл бат орших болтугай. Баярлалаа.